

ХАЛХЫН ТҮШЭЭТ ХАН АЙМГИЙН ТҮШЭЭТ ЗАСГИЙН ХОШУУНЫ НУТГИЙН НЭГЭН ЗУРГИЙН СУДАЛГАА

Ж.Гэрэлбадрах

Халхын Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошуу 1693 онд байгуулагдаж 238 жил оршин тогтноод 1931 онд татан буугдсан билээ. Тус хошуу тухайн үедээ Халх Монголын хамгийн том нутагтай хошуудын нэгэнд тооцогдож байв. Түшээт засгийн хошууны нутгийн зураг лавтайяа 5 байдгаас 1868, 1901-1904, 1911 оны 3 зураг Үндэсний номын сангийн сан хөмрөгт байна.¹ Нөгөө 2 зураг (1914, 1922) хагас дутуу гэрэл зургийн шилэн хальс байдлаар хадгалагдаж байна. Энэ илтгэлд тус хошууны бүх зургийг бус, зөвхөн нэг зургийн талаар өгүүлнэ.

Энэ бол “Qalq-a-yin tüsiyetu qan ayimaу-un qan ayulan-uçiyulyan-u ded daruу-a nigen jerge nemegsen jасау ulus-un tüsiy-e güng çaydurjab-yin qosiyun-u nutuу-i wu-yin dürim kemjiyeber nigen dörbeljin-dür tabin ajarbolуan üyileddügsen jiruу” (Халхын Түшээт хан аймгийн Хан уулны чуулганы дэд дарга нэгэн зэрэг нэмсэн засаг улсын түшээ гүн Чагдаржавын хошууны нутгийг фу-гийн дүрэм хэмжээгээр нэгэн дөрвөлжинд тавин газар болгон үйлдсэн зураг) гэсэн нэртэй бор цаасан дээр хар бэхээр зурсан зураг юм. Уг зураг Монгол улсын ҮНС-ийн газрын зургийн сан хөмрөгт эхээрээ, гэрэл зургийн шилэн хальс байдлаар Үндэсний Төв Архивын Кино гэрэл зургийн баримтын төвд хадгалагдаж байна.

Газрын зураг 56 см х 44 см хэмжээтэй. Зургийн зүүн дээд буланд бүртгэлийн дугаарыг “912 (517.3) Т 924” гэж улаан өнгийн бэхээр бичжээ. Энэ зургийн одоогийн бүртгэлийн дугаар нь 823/96 юм. Хятад бичээсийн дээр ягаан өнгийн дөрвөлжин тэмдэг, яг доор нь улаан өнгийн онги О хэлбэртэй тэмдэг дарсан байна. Онги хэлбэртэй тэмдэг дотор “ulus-un nom-un sang” (улсын номын сан) гэсэн бичиг бүдэг харагдана. Мөн баруун дээд буланд ягаан өнгийн бүдэг дөрвөлжин тэмдэг даржээ. Газрын зураг доторхи дөрвөлжинг улаан өнгийн бэхээр татжээ.

Уг газрын зурагт он цагийг тэмдэглээгүй боловч үүнийг 1900-1904 оны хооронд зурсан хэмээн таамаглаж болох ажээ. Зах нийлэх хошуудын овоодыг тэмдэглэхдээ “Түшээт хан Насанцогт агсан” гэж бичсэн нь үүнийг нотолж байна. Халхын Түшээт хан Насанцогт 1900 онд нас барж, түүний орыг 1904 онд ач дүү Дашням нь залгамжилсан байдаг билээ.²

Газрын зургийн зүүн дээд талд хятадаар 图盟副盟长 (Түшээт хан аймгийн дэд чуулганы дарга) гэж бичсэн байна. Уг бичвэр монгол хошуудын газрын зургуудыг Манжийн сайдын газраас хураан цуглуулах, эсвэл бүртгэж байсан гэж үзэхэд хүргэж байна.

Уг зургийг яаж зурсан, тэр нь одоо цагийн газрын зургийн хэмжээстэй хэрхэн дүйж байгаа нь их сонирхолтой. Хошууны газрын зургийг фу-гийн дүрэм хэмжээгээр нэг дөрвөлжинд 50 газар гэсэн хэмжээсээр тооцож, өртөөний зам ба суурин өртөө, захын овоо, уул, нуруу, гол, нуур, булаг, хийд, ноёны өргөөг зохих тэмдэгээр тэмдэглэжээ.

¹ Ч.Нарантуяа. Монгол дахь монгол гар бичмэл судрын гарчиг. УБ., 2008. т. 39-41

² Монгол улсын шастир. I. кирилл бичигт буулгаж, хэвлэлд бэлтгэн, тайлбар хийсэн А.Очир, З.Лонжид, Ц.Төрбат. УБ., 1997. т. 6-7

Ж.Гэрэлбадрах

Монголын Улсын Боловсролын их сургууль
gerelbadrakhdj@gmail.com

С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра

Монголын газрын зураг, газрын нэр судлал


“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6

Нэг дөрвөлжинд 50 газар (газар-576 метр) багтаасан уг хэмжээсийг баримтлан тооцвол, Түшээт засгийн хошууны нутаг хойноос урагш 16.7 дөрвөлжин буюу 480.960 метр (16.7 х 50 газар х 576 метр = 480.960 метр) урт болохоор байна. Өнөөгийн Монгол улсын газрын зургийн хэмжээсээр үзвэл тус хошууны нутаг уртрагийн дагуу буюу зүүн хойд захын Хадны усны (Дундговь аймгийн Эрдэнэдалай сум) овооноос өмнөд цэг Орвог гашууны Бор (Өмнөговь аймгийн Номгон сум) толгой хүртэл 507 километр (507.500 метр) байгаагаас үзэхэд фу-гийн дүрмээр зурсан дөрвөлжин хэмжээс нилээд алдаатай нь харагдана. Энд лавтайяа 26 (26.540 метр) километрийн дутуу зөрөө байна.

Тус хошууны нутгийн зүүнээс баруун хүртэлх хэмжээ өргөргийн дагуу нийт 10.6 дөрвөлжин газар буюу 305.280 метр (10.6 х 50 газар х 576 метр = 305.280 метр) байна. Одоогийн газрын зургийн хэмжээсээр бол нутгийн хамгийн баруун захын Улаан нуурын баруун хойд (Өмнөговь аймгийн Мандал-Овоо сум) эргээс зүүн захын Угалз уул (Дундговь аймгийн Өлзийт сум, одоо Аргалт уул гэж нэр нь өөрчлөгдсөн) хүртэл 266 (266.250 метр) километр байна. Харин энд 39 (39030 метр) километрээр илүү зурсан зөрөө гарч байна.

Үүнээс уг газрын зургийн хэмжээс алдагдсан, бодитой биш байна хэмээн дүгнэж болно. Гэхдээ фу-гийн дүрэм буюу нэг дөрвөлжинд 50 газар, эсвэл 100 газар багтаасан хэмжээсээр зурсан бүх газрын зургийг алдаатай гэж хэлэхэд арай эрт байна. Энэ нь тэдгээр газрын зургийн олонхийг нарийн хэмжээний дараа илүү тодорхой болох юм.

Газрын зураг зурахад хэрэглэдэг зурхайн хүрдний зүг чигийг заасан морь (урд зүг), туулай (зүүн зүг), тахиа (баруун зүг), хулгана (хойд зүг) зэрэг нийт 24 зүг чигийн нэрийг нутгийн зураг ба захын овоодын нэрсийн гадна талаар бичжээ. (Зураг.)



Уг газрын зурагт бүтэн дөрвөлжин хавтгай 94, хагас хавтгай 7, талаас бага хавтгай 32 байна. Хагас ба хагасаас бага хэсгүүдийг нэгтгэвэл 12 бүтэн хавтгай болохоор байна. Ингэвэл бүгд 106 дөрвөлжин хавтгай ба үүнээс өртөөдийн нутагт багтах 9 дөрвөлжинг хасвал 97 хавтгай болно. Гэхдээ тус хошууны үүнээс бус бусад бүх зурагт өртөөг нутагтаа оруулан зурсан байдгийг бодох хэрэгтэй. Хэдийгээр өртөөд бага ч гэсэн өөрийн нутагтай байсан боловч хошуудын нутаг дээр байгуулагдсан тул тухайн хошууны нутагт тооцогдсоор ирсэн билээ. Түшээт засгийн хошууны 106 дөрвөлжин нь 152640000 хавтгай дөрвөлжин метр (106 х 50 х 50 х 576 = 152640000 метр) нутагтай болж байна. Энэ нь

152640 хавтгай дөрвөлжин километр нутаг болох юм.

Энэ зургийн нэг онцлог бол хошууны нутгийн захын овоодыг нэгдсэн байдлаар дугаарлаагүй явдал юм. Газрын зурагт хошууны нутгийн захын 119 овоог 10 хэсэг болгон тэмдэглэхдээ тус бүрд нь 1-ээс эхлэн дугаарлажээ. Чухам яагаад ингэж бичих болсныг

тайлбарлаж чадахгүй байна. Харин тэр үеийн Монголын ихэнхи газрын зурагт хошуудын нутгийн захын овоодыг морин зүг буюу өмнө талаас нь эхлэн нар зөв эргүүлэн нэгдмэл байдлаар дугаарласан байдаг билээ. Магадгүй энэ зургийг Манжийн Чин улсын Шинэ засгийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан яаруу сандруу үйлдсэн байж болох юм. Ингэж үзэх үндэслэлийг дээрх хятадаар бичсэн тэмдэглэл ба үйлдсэн он цаг давхар нотолно.

Тус газрын зурагт тэмдэглэсэнээр Түшээт засгийн хошууны нутагт Манжийн “үржүүлэх тэмээ адгуулах газар” гурав байжээ. Тэдгээрийн нэг нь Улаан нуурын хойд бие Шивээгийн талд (Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын баруун хойд нутаг), хоёрдахь нь Бага Шанхайн уулын баруун талд (энэ уул хаана байгааг мэдэж чадсангүй, багцаагаар харахад Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг), гуравдахь нь Хөрхийн нурууны зүүн талын Шар модны тал, Товогийн талаар (Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын баруун өмнөд нутаг) тус тус оршиж байв. Эдгээр тэмээн сүргийг “үржүүлэх тэмээ” гэж тодотгосон байх тул Манжийн хааны тэмээ болов уу гэж бодож байна.

Тус газрын зурагт нийтдээ 60 уулыг бараан цэнхэр өнгөөр зурж, нэрийг нь хар бэхээр бичжээ. Ингэхдээ уулын өндрийн хэмжээг бичээгүй байна. Тэдгээрийг 2011 оны Өмнөговь аймгийн 750.000, Дундговь аймгийн 500.000 хэмжээтэй газрын зургаас хайж үзэхэд 20 уул байна. Зурагт буй 60 уулаас 20 нь өнөөгийн газрын зурагт байна гэдэг нь арай бага үзүүлэлт юм. Зарим жижиг уул, овооны нэр 100 гаруй жилийн хугацаанд өөрчлөгдсөн байж болох талтай. Эсвэл өнөөгийн газрын зурагт зарим жижиг уул овоог нарийвчлан тэмдэглээгүй ч байж болно. Гэтэл энэ газрын зурагт харьцангуй томоор зурагдсан Их Луус уул, Бага Луус уул, Бага Шанхай уул зэрэг цөөнгүй уулс одоогийн газрын зургаас олдохгүй байгаа юм.

Газрын зурагт булаг 2 (Гурван булаг, Сүүжийн ус булаг), гол 1 (Онги гол)-ийг зурж, нэрийг бичсэн ба Улаан нуурыг долгиолуулан зурж, нэрийг нь Хурган өлөн гэжээ. Магадгүй тэр үед нуур тийм нэртэй байсан байж ч болох юм. Хэрэв тийм бол Улаан нуур гэдэг нэр сүүлд бий болсон, нуурын язгуур нэр нь Хурган өлөн байжээ. Гол ба нуурыг цэнхэр өнгөөр зурсан байна.

Зарим уул нурууны байрлалыг илт буруу зурсан нь харагдана. Тухайлан Их Шанхайн нуруунаас баруун урд 22 км-т орших Цэций уулыг (Өмнөговь аймгийн Цогтцэций сум) түүний баруун хойно 25 орчим газар зурсан, Дэлгэрхангай уулаас чанх зүүн зүгт 52 км-т байх Хулд уулыг (Дундговь аймгийн Хулд сум) түүнээс баруун урагш 100 орчим газрын (Дундговь аймгийн Дэлгэрхангай сум) өмнө зурсан зэргийг дурдаж болно.

Түшээт засгийн хошууны хойд нутгийн дундуур Чуулалт хаалган-Улиастайн чиглэлийн 6 өртөө дайран (Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын урд нутгаар) гардаг байжээ. Тус газрын зурагт өртөөдийн тэмдэглэгээг уламжлалт ромбо хэлбэртэй \diamond гэсэн тэмдгээр зурж, цэнхэрээр буджээ. Тэдгээр нь Хярын жирэм (Замын гашуун жирэм), дам Шагшарга (Мэнгэт шагшарга-Ж.Г), Цавчир, дам Хашаат (Хашаат хад-Ж.Г), Зээрэн, Онги (Бүүрцэг Онги-Ж.Г) гэсэн өртөөд байжээ. Газрын зургийн хэмжээсээр баримжаалбал суурь өртөө хоорондын зай 50 дөнгөж илүү газар буюу $(50 \times 576 \text{ м} = 28800 \text{ метр})$ 28800 метр байна. Мөн нэг өртөөний нутаг хааш хаашаагаа 50 газрын $(50 \times 50 \times 576 \text{ м} = 1440000 \text{ метр кв буюу } 1440 \text{ км кв})$ буюу 1440 км кв хэмжээтэй байгаа нь бас харагдана.

Бас тус хошуу зүүн хойд талаараа Хөтөл долоон, Тал долоон буюу Сайр ус, Модон, дам хавсарга өртөө (Хавирга булаг-Ж.Г), Шувуутай (Шар шувуутай-Ж.Г), Луус (Луус Зайрмагтай-Ж.Г) гэсэн 6 өртөөний нутагтай зах нийлдэгийг зурж гаргажээ. Энэ бүхэн нь нийтэд ихэд тархаж танил болсон “Өртөө харуулуудын зураг” (XIX зууны эхэн үе) гэсэн зураг дахь нэрстэй үндсэндээ дүйж байна. Өөрөөр хэлбэл, уг зурагт өртөөдийн нэрийг зөв тэмдэглэжээ.

Хошууны засаг ноёны тамгын газар Дэлгэрхангай уулын зүүн хэсгийн Инил уулын өмнөд бэлд байсныг зурж, бас бичжээ. Мөн Онгийн голын баруун хөвөөнд орших “Өлзийгөөр арвижуулагч сүм” (одоогийн Бари ламын хийд), “Гайхамшигт сайн билигт сүм” (одоогийн Хутагт ламын хийд), зүүн хөвөөн дэх “Хотол өглөгт сүм” (одоогийн

Гүндүжамбаалин хийд), Баян уулын өвөр дэх “Шажныг хөгжүүлэгч сүм”, Хөрх уулын өвөр дэх “Бүхнийг бүтээгч сүм” гэсэн 5 том хийдийг зурж, нэрийг нь бичжээ.

Түшээт засгийн хошуу дэлхийн бөмбөрцөгийн уртрагийн дагуу буюу хойноос урагш сунаж тогтсон нутагтай байжээ. Энэ нь хээр, говь, цөл гэсэн байгалийн 3 бүсийг дамнан оршиж байгаа гэсэн хэрэг бөгөөд нүүдлийн мал аж ахуй эрхлэн хөтлөхөд тун тохиромжтой байрлал юм.


Хойд нутаг хээрийн бүсэд зуд болбол урагшаа цас бага ордог говь, цөлийн нутаг руугаа нүүнэ. Өмнөд нутаг болох цөл ба говийн бүсэд ган болбол хойд нутаг бороо арай ахиу ордог хээрийн бүс рүүгээ нүүнэ. Энэ бол сонгодог нүүдлийн мал аж ахуй эрхлэх үндсэн арга юм. Үүний нэг сонгомол жишээ бол “Хорин тав баг”-ийн нутаг юм. Тус баг хоёр нутагтай. “Хойд Хорин тав баг” нутгийн хойд талд Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт байна. “Урд Хорин тав баг” нь Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт байжээ. Нэгдмэл 1 захиргаатай. Адилхан нэртэй 2 хийд хойд ба урд багт байдаг. Тэр нь Сангийн далай хийдүүд юм. Хойд Сангийн Далай хийд Эрдэнэдалай сумын төвд, Урд Сангийн Далай хийдийн туурь Номгон сумын төв дээр байна. Тус багийн харьяат нарт ган, зуд тохиолдвол аль нэг баг руугаа нүүж, өвөлжиж эсвэл зусаад эргэж ирнэ. Хойд багтаа адуу, хонь ихтэй бол урд багтаа тэмээ, ямаа илүүтэй маллана.

Уг газрын зурагт уламжлал ёсоор хошууны дотоод засаг захиргааны хуваарийн талаар ямар нэгэн зүйл тэмдэглээгүй байна. Түшээт засгийн хошууны хүн амын тооллогын баримтад ноёны хамжлага, зангийнхаа нэрээр нэрлэсэн 4 сум, тайж нарын харьяат, 40 лам зэргээс бүрдэж байсан тухай л дурдсан байдаг. Албан ёсны баримт бичиг ба бодит амьдрал


дээрх засаг захиргааны хуваарь хоёр тэс ангид байдаг нь Түшээт засгийн хошуунд бас харагдана.

Нэрт түүхэн газарзүйч О.Пүрэв аругайн судлан гаргаснаар XX зууны эхэн үед Түшээт засгийн хошууны нутгийн дотоод хуваарь доорхи байдалтай байв. Хойд хорин тав баг, Хойд хондого сум, Гол сум, Шинэ хиа нар баг, Мэргэн ахайн хэсэг, Сайхан сум, Хуучин хиа нар баг, Дөч баг, Авган сум, Дайчингуудын хэсэг, Зургаа баг, Харцагын арван, Урд хорин тав баг, Урд хондого сум, Долоо баг, Их арван баг, Толийн арван баг гэсэн 17 хэсэгт хуваагдаж байжээ. (Зураг.) Мөн тус хошуунд Халхын шарын шашны тэргүүн Жибзундамба хутагтын Номч билигт хутагтын 2 отог, Дайчин, Хичээнгүй зэрэг 12 отог, нийт 14 отог оршиж байсан байна.

Тухайн хошууны газар нутаг одоогийн Монгол улсын ямар аймаг, сумдын нутгаар оршиж байсан бэ? Тус хошуу Өвөрхангай аймгийн Баян-Өндөр, Сант, Баянгол сумдын зүүн өмнөд



нутаг, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын ихэнхи нутаг (хойд хэсэг нь орохгүй), Сайхан овоо, Дэлгэрхангай, Хулд сум бүхэлдээ, Өлзийт сумын ихэнхи нутаг (зүүн хэсэг нь орохгүй), Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Цогт-Овоо, Цогтцэций, Номгон, Баян-Овоо сумд бүхлээрээ, Булган сумын зүүн нутаг, Ханхонгор, Даланзадгадын ихэнхи нутаг (баруун хэсэг нь орохгүй), Ханбогд сумын баруун талын нутаг тус тус багтаж байжээ. Түшээт засгийн хошууны газрын зургийг одоогийн Монгол улсын засаг захиргааны хуваарь дээр тавьж үзвэл доорхи байдалтай харагдана. **(Зураг.)** Энэ бол тойм байдлаар тавьсан харьцуулалт тул зарим сумдын нутаг орохгүй байгаа юм. Учир нь одоогийн газарзүйн солбицлыг нарийн баримталбал уг эх зургийн хэлбэр хэт алдагдахад хүрч байгааг уншигч абугай та болгоох буй за.



Газрын зурагт тэмдэглэсэн нутгийн захын овоодыг баримтлан тус хошууны нутаг ямар байдалтай байсныг багцаа байдлаар тодруулах боломж бий. Харин олон овоодын нэрс одоогийн газрын зурагт бичигдээгүй, эсвэл нэр нь өөрчлөгдсөн зэргээс үүдэн нарийн гаргах боломжгүй байна.

Ямар боловч дөрвөн зүг, найман зовхисын заримыг тодорхойлж болж байна. Тэдгээрийг дурдвал, өмнөд цэг нь Орвог гашууны савын овоо (Орвог гашууны Бор толгой-Номгон сум), баруун өмнөд зовхис Ончийн савын овоо (Онч хайрхан уул, Ончийн овоо-Номгон сум), баруун цэг Тэвшийн гашууны зүүн этгээд Тэгээгийн оройн савын овоо (Улаан нуурын баруун өмнөд бие-Булган сум), баруун хойд зовхис Борцэг уулын савын овоо (? - Баян-Өндөр сум), хойд цэг нь Ламын хонгорын савын овоо (? - Эрдэнэдалай сум), зүүн хойд зовхис Хадан усны савын овоо (Хадан усны рашаан- Эрдэнэдалай сум), зүүн цэг Гэр хүйтний овоо (Аргалт уул - Өлзийт сум), зүүн урд зовхис Зээрд азаргын Шинэ цагаан овооны савын овоо (Гурван зээрд - Ханбогд сум) зэрэг юм.

Энэ зурагт Түшээт засгийн хошуутай зах нийлэн оршиж байсан хошуудыг нутгийн захын овоодыг бичихдээ тодорхойлсон байна. Том хошуу байсан тул олон хошуудтай нутаг залгаж байв.

- урд талаараа Өвөр Монголын Улаанцавын чуулганы Урад баруун хошуу, Алашаагийн Өөлд хошуу,
- баруун талаар Сайн ноён аймгийн Ёст засгийн хошуу, Сайн ноёны хошуу, Үйзэн засгийн хошуу,
- хойд талаар Сайн ноён аймгийн Илдэн засгийн хошуу, Түшээт хан аймгийн Далай засгийн хошуу, Түшээт ханы хошуу, Сэцэн засгийн хошуу, Дайчин засгийн хошуу,
- зүүн талаар Түшээт хан аймгийн Дайчин засгийн хошуу, Ачит засгийн хошуу, Эетэй засгийн хошуу, Мэргэн засгийн хошуу гэсэн нийт 14 хошуутай нутаг нийлж байжээ.


Энэ зургаас урьд өмнө Түшээт засгийн хошууг Урадын баруун ба урд гэсэн хоёр хошуутай зах нийлдэг байсан гэж зурагласаар ирсэн бидний газрын (Ж.Гэрэлбадрахын) зураг алдаатайг олж харав.³ Мөн тус хошууг Улаанцавын чуулганы Халх баруун гарын хошуу ба Урадын 3 хошуутай зах нийлдэг байснаар зурсан зарим (проф. О.Пүрэв абугайн) зураг⁴ ч буруу болсныг хүлээн зөвшөөрч байна.

Ийнхүү Түшээт засгийн хошууны энэ нэгэн зургаас - үүнийг 1900-1904 оны хооронд зурсан болох, - одоогийн зурагтай харьцуулан үзвэл хэмжээ багагүй алдсан, - зарим уулын байрлалыг буруу зурж тэмдэглэсэн, - Манжийн хааны тэмээ сүрэг 3 газар байсан, - хошууны нутгаар дайран гардаг өртөөдийн нэрийг үнэн зөв тэмдэглэсэн, - захын овоодыг нэгдсэн байдлаар дугаарлаагүй, - одоогийн ямар аймаг, сумдын нутгийн хамран оршиж байсан, - бидний үед зурсан зарим түүхийн зураг алдаатай болсныг нотолсон зэрэг цөөнгүй зүйлсийг мэдэж авна.

Цаашид тус хошууны нутгийн бүх зургийг харьцуулан судлах аргаар газар нутгийн өөрчлөлт гарсан эсэх, одоогийн газрын зурагт тодорхойгүй буй уул ба захын овоодыг нягтлан газар нутгийн хэмжээг гаргах зэрэг нарийн чимхлүүр ажлуудыг хийж болох юм.

³ Монголчуудын нэгдсэн улс байгуулахын төлөөх тэмцэл (1911-1915). Баримт бичгийн эмхтгэл II. УБ., 2014. т.283

⁴ XX зууны эхэн үеийн Ар Монгол (1900-1930). Зургийг зохиож, редакторласан түүхийн шинжлэх ухааны доктор Хар дархад О.Пүрэв. УБ., 2004



Халхын Түшээт хан аймгийн Хан уулын чуулганы дэд дарга, нэгэн зэрэг нэмсэн засаг улсын түшээ гүн Чагдаржавын хошууны нутгийг фу-гийн дүрэм хэмжээгээр нэгэн дөрвөлжинд тавин газар болгон үйлдсэн зураг

- Мөн гүн Батсуурь, нэгэн аймгийн засаг Бадрахын хошуу лугаа манай хошууны уул нутгийн зах болгосон нэгдүгээр Бортовогийн овоо.
Хоёрдугаар Хөтөлдолоон, Бор-Овоо хоёр өртөөдийн хоорондох Загийн усны өмнө дэвсэгийн савын овоо дээр засгаас огцруулсан Сономдоржийн хошуу зах нийлэлдмүй.
- Хоёрдугаар Гэрхүйтэний овоо
Гуравдугаар Хүүборын савын овоо
Дөрөвдүгээр Тахилгат өндөрийн савын овоо
- Тавдугаар Тахилгатын арын савын овоо
Зургаадугаар мөн Тахилгатын өврийн овоо
Долдугаар Хүүборын усны овоо
Наймдугаар Цацайтайн усны овоо
Есдүгээр Наранбулагийн усны овоо
Аравдугаар Манханы овоо
Арван нэгдүгээр Амгалангийн усны савын овоо

- Арван хоёрдугаар Улаанчихийн савын овоо
- Арван гуравдугаар Муруйн усны савын овоо
- Арван дөрөвдүгээр Наримын Харын зүүн үзүүрийн овоо
- Арван тавдугаар Хацавчийн Бортолгойн овоо
- Мөн засгаас огцруулсан Сономдорж, хэбэй ван Ананд-Очир манай гурван хошууны зах нийлэх Хадны усны савын овоо
- Хоёрдугаар эхний Хэрс овоо
- Гуравдугаар Хар нэгэн хөтлийн овоо
- Дөрөвдүгээр Гүнтолгойн овоо
- Тавдугаар Элсний овоо
- Зургаадугаар Шараацарын савын овоо
- Долдугаар Хөх хадны савын овоо
- Наймдугаар Бумбатын савын овоо
- Есдүгээр Савагийн усны овоо
- Аравдугаар Бор овооны овоо
- Арван нэгдүгээр Хөх хадны савын овоо
- Арван хоёрдугаар Буурал бутны савын овоо
- Арван гуравдугаар Бурхантын савын овоо
- Арван дөрөвдүгээр Таван овооны савын овоо
- Арван тавдугаар Хулсны савын овоо
- Арван зургаадугаар Буйлсны овоо
- Арван долдугаар Бага модны савын овоо
- Арван наймдугаар Саваг усны овоо
- Арван есдүгээр Цагаан эргийн савын овоо
- Хорьдугаар Хээрийн савын овоо
- Хорин нэгдүгээр Олон шандны савын овоо
- Мөн хэбэй ван Ананд-Очир, чуулганы Урадын гүн Бавуудоржийн зах нийлэх Зээрд азаргын Шинэ цагаан овооны савын овоо
- Мөн да гүн Бавуудорж манай хоёр хошууны зах нийлэх хоёрдугаар Цагаан толгойн савын овоо
- Гуравдугаар Бор овооны савын овоо
- Дөрөвдүгээр Эргэнэгийн савын овоо
- Тавдугаар Модон овооны савын овоо
- Зургаадугаар Бор хошууны савын овоо
- Долдугаар Сухайтын өтөгийн савын овоо
- Наймдугаар Улаан тэгээгийн савын овоо
- Есдүгээр Бор саарийн савын овоо
- Аравдугаар Таван худгийн савын овоо
- Арван нэгдүгээр худаг Заг гашууны савын овоо
- Арван хоёрдугаар Цагаан тэгээгийн савын овоо
- Арван гуравдугаар Дунд сэвхүлийн савын овоо
- Арван дөрөвдүгээр Улаан толгойн савын овоо
- Арван тавдугаар Баян харын савын овоо
- Арван зургаадугаар Цагаан гашууны савын овоо
- Арван долдугаар Цагаан толгойн савын овоо
- Арван наймдугаар Наранбулагийн савын овоо
- Арван есдүгээр Сайнигийн савын овоо
- Хорьдугаар Дэвсэгийн савын овоо
- Хорин нэгдүгээр Загийн захын савын овоо
- Хорин хоёрдугаар Хар толгойн савын овоо
- Хорин гуравдугаар Элсний тэгээгийн савын овоо

- Хорин дөрөвдүгээр Загийн захын савын овоо
- Хорин тавдугаар Тэшигийн савын овоо
- Хорин зургаадугаар Хүрэн цавын савын овоо
- Хорин долдугаар Цагаан бухын савын овоо
- Хорин наймдугаар Хар дэлийн савын овоо
- Хорин есдүгээр Тооройн савын овоо
- Гучдугаар Олстойн савын овоо
- Гучин нэгдүгээр Улаан толгойн савын овоо
- Гучин хоёрдугаар Алаг улааны савын овоо
- Гучин гуравдугаар мөн гүн Бавуудорж, Өөлдийн ван Долдсэрэн манай гурван хошууны зах нийлэх Жүсийн гүний савын овоо
- Мөн ван Долдсэрэн манай хоёр хошууны зах нийлэх хоёрдугаар Орвог гашууны савын овоо
- Гуравдугаар Жинхэний усны савын овоо
- Мөн ван Долдсэрэн, Сайн ноён аймаг засаг Балдан манай гурван хошууны зах нийлэх Ончийн савын овоо
- Хоёрдугаар Их бага Хүүборын савын овоо
- Гуравдугаар Бэлэгдалайн савын овоо
- Дөрөвдүгээр Шивээтийн савын овоо
- Тавдугаар Улаантолгойн савын овоо
- Зургаадугаар Сайн шандны савын овоо
- Долдугаар Доголонгийн Улаантолгойн савын овоо
- Наймдугаар Баруун Номгоны савын овоо
- Есдүгээр Дулаан харын (Тулга харын ?) савын овоо
- Аравдугаар Бага хүйтний баруун этгээд савын овоо
- Арван нэгдүгээр Нүцгэн булгийн баруун этгээд савын овоо
- Мөн засаг Балдан да, Сайн ноён манай гурван хошууны зах нийлэх арван хоёрдугаар Тэвшийн гашууны зүүн этгээд Тэгээгийн оройн савын овоо
- Мөн да, Сайн ноён тэдний аймаг гүн Дэчинравдан манай гурван хошууны зах нийлэх Цагаан хадамны овоо
- Хоёрдугаар Хонгилцавын савын овоо
- Гуравдугаар Хар чулууны савын овоо
- Дөрөвдүгээр Хоромсогын савын овоо
- Тавдугаар Агар уулын савын овоо
- Зургаадугаар Боржигэдийн гашууны овоо
- Долоодугаар Гучингийн усны баруун этгээдийн савын овоо
- Наймдугаар Тагналтайн савын овоо
- Сайн ноён аймгийн засаг гүн Цэрэндоржийн хошуу лугаа байгуулсан Борэчэг уулын савын овоо
- Сайн ноён аймгийн бэйл Дондовжанцалын хошуу лугаа манай хошууны зах нийлэх нэгдүгээр Зээрэн нуурын Бор довогийн овоо
- Мөн бэйл Дондовжанцал, манай нэгэн аймаг гүн Мипамчасодбавуудорж бидний гурван хошууны зах нийлэх Цохын бяцхан Бортолгойн савын овоо
- Хоёрдугаар Эрдэнэтолгойн савын овоо
- Гуравдугаар Булаг сүүжийн овоо
- Мөн гүн Мипамчасодбавуудорж, Түшээт хан Насанцогт агсан, манай гурван хошууны зах нийлэх бүхийн Ногоон толгойн овоо
- Хоёрдугаар Баахан Хашаатын овоо
- Гуравдугаар Цагаан урагтын овоо
- Дөрөвдүгээр Авдарын овоо
- Тавдугаар Шабигийн овоо

- Зургаадугаар Ар Угтаалын овоо
 Долдугаар Дөрвөлжингийн оройн овоо
 Наймдугаар Улаан тойромын овоо
- Мөн Түшээт хан Насанцогт агсан, гүн Мишигдорж, манай гурван хошууны зах нийлэх Ламын Хонгорын савын овоо
 Хоёрдугаар Цагаан тэмэгтийн баруун хярын овоо
 Гуравдугаар Бүхдарь нуур сав Улаантолгойн овоо
 - Мөн гүн Мишигдорж, гүн Батсуурь манай гурван хошууны зах нийлэх Хадны усны савын овоо
 Хоёрдугаар Улаантолгойн савын овоо
 Гуравдугаар Сайн хаяа-гийн овоо
 Дөрөвдүгээр Цагаан усны овоо
 Тавдугаар Замын гашууны савын овоо
 Зургаадугаар Буйлсутын оройн овоо
 Долдугаар Үнэгтэйн савын овоо
 Наймдугаар Баян улааны савын овоо
 Есдүгээр Товгор толгойн савын овоо
 Аравдугаар Хараатын оройн савын овоо
 Арван нэгдүгээр Улаан худагийн савын овоо
 - Цагаан гүвсэний овоо, Муу бэлгүүн овоо - Хөтөл долоон өртөө
 Алтганы усны овоо - Тал долоон өртөө
 Хөтлийн бууцны хойд хөтлийн овоо - Модон өртөө
 Үл олдохын овоо - дам хавсарга өртөө
 Хүрз алдахын овоо - Шувуутай өртөө
 Хөх толгойн овоо - Хярын жирэм өртөө
 Жаргалант овоо - дам Шагшарга өртөө
 Хадахын дунд усны овоо - Цавчир өртөө
 Хар нүдний овоо - дам Хашаат өртөө
 Хонгорын хаяа худгийн овоо - Зээрэн өртөө
 Өлгөний хаяа худгийн овоо

SUMMURY

Tusheet Zasag banner of Khalkh'sTusheet Khan aimag was established in1693, existed for 238 years and dissolved in 1931. It was one of the largest banners of Khalkh Mongol. There are 5 distinct maps of the territory of Tusheet Zasag banner and 3 of them were created in 1868, 1901-1904 and 1911. They are kept in the fund of the National Library and 2 of them (1914, 1922) are partially survived in the photo form. In the present paper, not all but one of these maps is being described.

It is a map named “Qalq-a-yin тsiyetu qan ayimag-un qan agulan-učigulan-u ded darug-a nigen jerge nemegsen jasag ulus-un түsiy-e güng čagdurjab-yin qosigun-u nutug-i wu-yin дьrim kemjiyeber nigen дүрbeljin-дүр tabin gajarbolan ьyiledдьgsen jirug” which was drawn on the brown paper with black ink.

The map is originally kept in the map fund of National Library and in the photo document center of the National Archive in the digital format.

Its size is 56 cm x 44 cm. The registration number “912 (517.3) T 924” is ticketed in red ink on the upper-east corner. The present registration number of the map is 823/96. The map is speculated to be drawn in 1900-1904, though there is not any date noted on it.

We also consider that the measurement of the map was done incorrectly and it is not accurate. The locations of some mountains and ranges were clearly drawn with some errors. The paper provides details of all the characteristics of the map, and points out the mistakes and conclusions drawn.

Henceforth, by comparing all these maps of the banner, we can do more researches to achieve more accuracy and find out if there are any changes in the territory of the banner, to determine the size and boundaries of the territory and to introspect the mountains and ovoos (cairn erected as a shrine) that modern maps do not show.